



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/212

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, 65 дугаар зүйлийн 65.1.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан журмын 2.3 дахь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 1.5.3-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхэд болон эмэгтэйчүүдийн эрх ашиг аюулгүй байдлыг хамгаалах, хүүхдийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхэд болон бусад этгээдэд яаралтай тусламж үзүүлэх түр хамгаалах байрны 2017 оны үйл ажиллагааны зардалд 6874000 төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Түр хамгаалах байрны зардлын төсвийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Түр хамгаалах байрны үйл ажиллагаанд шаардагдах 6874000 /зургаан сая найман зуун далан дөрвөн мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01-965

Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дугаар сарын 02 өдрийн А/212
дугаар захирамжийн хавсралт

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байрны
2017 оны үйл ажиллагаанд шаардагдах төсөв

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг удаагийн үнэ	Бүгд
Цалин				
1	Нийгмийн ажилтны цалин	12 сар	450.000	5.400.000
2	НД шимтгэл	12 сар	49.500	594.000
	Цалин дүн			5.994.000
Болзошгүй эрсдэлийн зардал				
3	Эм тариа	4 улирал	25.000	100.000
4	Унаа	12 сар	15.000	180.000
5	Холбоо	12 сар	5.000	60.000
6	Хоол	12 сар	45.000	540.000
	Дүн			880.000
	Нийт дүн			6.874.000